

## ***New transfer pricing rules in Mongolia***

### **Contacts:**

#### **Michael Ahern**

Partner, Leader of Tax and Legal Services, Eurasia  
michael.ahern@kz.pwc.com

#### **Tsendmaa Choijamts**

Executive Director, Tax Services  
tsendmaa.choijamts@mn.pwc.com

#### **Maryna Tarnavska**

Manager, Tax Services  
tarnavska.maryna@mn.pwc.com


#### **PwC Tax TMZ LLC**

Central Tower 6th floor.  
Suite 603, Ulaanbaatar  
14200, Mongolia  
Tel : + 976 70009089  
Fax : +976 11 322068

**[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)**

This Alert is produced by PwC Tax TMZ LLC. The material contained in this alert is provided for general information purposes only and does not contain a comprehensive analysis of each item described. Before taking (or not taking) any action, readers should seek professional advice specific to their situation. No liability is accepted for acts or omissions taken in reliance upon the contents of this alert.

© 2017 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC. All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



*The Ministry of Finance and the Mongolian Tax Administration ("MTA") have developed regulations strengthening the current transfer pricing ("TP") rules.*

*The new regulations define the covered transactions more specifically, introduce the tools for analysing TP, determine TP documentation, stipulate the reporting requirements and establish other important rules.*

*The major issues include:*

### **TP Methodology**

The previous Methodology for setting benchmark prices\* (in force since 2007) was replaced by the new Methodology\*, which now became publicly available. The new Methodology establishes detailed rules based on the OECD's TP Guidelines for Multinational Enterprises and Tax Administrations.

The Methodology includes the following

#### ***Scope of TP regulations (covered transactions)***

- TP rules will apply to virtually all types of transactions between related parties.

#### ***Definition of "related parties"***

- The definition of 'related parties' refers to Article 48 of the General Tax Law, Article 11 of the Corporate Income Tax Law and Article 9 of relevant double tax treaties ratified by Mongolia:
  - The current definition of related parties in the Corporate Income Tax Law is limited to vertical participation in shareholding, dividend distributions or management of 20% and more.
  - However, the General Tax Law set a broader definition of related persons for TP purposes, which ~~virtually~~ includes almost all persons authorized to directly and indirectly participate in management, control and property rights of any foreign and Mongolian legal entities.

\*Approved by the Ordinance of the Minister of Finance No. 86 of April 2007

\*Approved by the Ordinance of the Minister of Finance No. 353 of 24 December 2015

## **TP concepts**

- Basic TP concepts commonly used in internationally recognised practice will be introduced, including: comparability analysis, internal and external comparables, economic benefit, etc.

## **TP methods**

- Similar to the OECD's TP Guidelines for Multinational Enterprises and Tax Administrations, there will be five methods for TP analysis:
  - Comparable uncontrolled price method
  - Cost plus method
  - Resale method
  - Profit split method
  - Transactional net margin method
- The previous TP rules established only the first three methods (so-called "traditional transaction methods") from the above list.
- Any of the five methods can be used following the most appropriate method approach i.e., that provides the best estimation of an arm's length result in each particular case.

## **TP documentation and reporting requirements**

### **TP documentation**

- TP documentation will need to be maintained for all transactions subject to TP rules and should be presented to the tax authorities on their request within 20 working days.

### **TP reporting**

- All affected taxpayers should file a report on covered transactions on a semi-annual and annual basis.
- The format of the report was introduced by the MTA's General Department of Taxation (Form XXM-01)\*, and the first reporting must be done from the second quarter 2017.

- The TP report includes the following:
  - information about related parties;
  - information about the related-parties' transactions;
  - amount of income (profit) and/or expenses related to the covered transaction, its profitability;
  - TP method(s) applied for the covered transactions;
  - list of comparable entities used for a benchmarking study;
  - information about recent restructuring of the group (if any);
  - information about changes in ownership (if any).

Clearly, the MTA is now focused on TP. Businesses with related-party transactions will need to be treated with extreme attention given the increased TP requirements.



\*Approved by the Ordinance of the Commissioner No. A/96 of 28 April 2017

# Татварын мэдээлэл

Монгол Улс • Дугаар 2/2017 • 2017 оны 5 дугаар сарын 29-ны өдөр

## Монгол Улсын Үнэ шилжүүлэл- тийн шинэ журам

### Холбогдох хаяг:

#### Майк Ахэрн

Партнёр, Татвар болон хуулийн  
үйлчилгээний удирдагч,  
ЕвроАзи  
michael.ahern@kz.pwc.com

#### Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал  
Татварын зөвлөх үйлчилгээ  
tsendmaa.choijamts@mn.pwc.com

#### Марина Тарнавска

Менежер  
Татварын зөвлөх үйлчилгээ  
tarnavska.maryna@mn.pwc.com

#### PwC Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар  
603 тоот, Улаанбаатар  
14200, Монгол Улс  
Утас: +976 70009089  
Факс: +976 11 322068

[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зориулттай бөгөөд энэд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (үл үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2017 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC. All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



*Сангийн Яам болон Татварын ерөнхий газар (ТЕГ)-аас өнөөгийн үнэ шилжүүлэлт (ҮШ)-ийн хууль тогтоомжийг сайжруулах зорилгоор журам боловсруулан гаргалаа.*

*Энэхүү шинэ журамд хамаарах ажил гүйлгээг нарийвчлан тодотгож, ҮШ-ийн шинжилгээний арга хэрэгслийг танилцуулан, ҮШ-ийн баримтжуулалт болон тайлагнах шаардлагыг тодорхойлох зэрэг бусад чухал зүйлсийг хамруулсан байна.*

*Бид уг журмын гол асуудлыг дараахи байдлаар танилцуулж байна.*

### ҮШ –ийн аргачлал

Өмнө нь гаргасан “Жишиг үнэ хэрэглэх аргачлал” (2007 оноос үйлчилсэн) өөрчлөгдөн, шинэ аргачлал гарсан ба үүнтэй олон нийт танилцаж болно. Шинэ аргачлал нь ЭЗХАХБ-ын үндэстэн дамнасан аж ахуйн нэгж болон татварын албанд зориулсан үнэ шилжүүлэлтийн заавартай нийцсэн нарийн асуудлуудыг тусгаж өгсөн. Аргачлалыг танилцуулбал:

#### **ҮШ –ийн зохицуулалтын цар хүрээ ( хамрагдсан ажил гүйлгээ)**

- ҮШ-ийн зохицуулалт нь харилцан хамааралтай этгээдүүдийн бүх төрлийн ажил гүйлгээнд үйлчилнэ.

#### **Харилцан хамааралтай этгээд (ХХЭ)-ийн тодорхойлолт**

- **ХХЭ** гэдгийг ТЕХ-ийн 48 дугаар зүйл, ААНОАТТХуулийн 11 дүгээр зүйл, Давхар татварын гэрээний 9 дүгээр зүйлээр тус тус тодорхойлсон байдаг:

➢ Одоогийн ААНОАТТХ-ийн ХХЭ-ийн тодорхойлолтоор зөвхөн босоо бүтцийн хувьцаа эзэмшилт, ногдол ашиг, удирдлагын 20 болон түүнээс дээш хувийн оролцоотой бол хэмээн хязгаарласан байдаг.

➢ Гэсэн хэдий ч ТЕХ-д ҮШ-ийн зорилгоор ХХЭ-ийн тодорхойлолтыг өргөн хүрээтэй тусган Монгол Улсын болон гадаад улсын аливаа хуулийн этгээдийн удирдлага, хяналт болон эд хөрөнгийн эрхэд нь шууд ба шууд бусаар оролцох эрхтэй этгээдийг хэлнэ хэмээсэн байдаг.

\*2007 оны 4 сарын Сангийн сайдын 86 тоот тушаалаар баталсан

\*2015 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн Сангийн сайдын 353 тоот тушаалаар баталсан

# Татварын мэдээлэл

Монгол Улс • Дугаар 2/2017 • 2017 оны 5 дугаар сарын 29-ны өдөр

## ҮШ-ийн үзэл баримтлал

- Олон улсын практикт хэрэглэж буй харцуулсан шинжилгээ, гадаад, дотоод харьцуулал, эдийн засгийн үр ашиг гэх мэт ойлголтуудыг багтааж ҮШ-ийн гол үзэл баримтлалыг нэвтрүүлэн танилцуулсан.

## ҮШ-ийн аргууд

- ЭЗХАХБ-ын үндэстэн дамнасан аж ахуйн нэгж болон татварын албанд зориулсан үнэ шилжүүлэлтийн зааврын адил ҮШ –ийн шинжилгээний 5 аргатай байна:
  - Харьцуулагдах үнийн арга
  - Өртөг дээр нэмэх арга
  - Дамжуулан борлуулах үнийн арга
  - Ашиг хуваах арга
  - Ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшингийн арга
- Өмнөх ҮШ-ийн журам нь дээрх жагсаалтын зөвхөн эхний 3 аргыг (уламжлалт ажил гүйлгээний аргууд) тусгасан байсан.
- Дээрхи 5 аргын аль тохиромжтойг сонгон авч ашиглаж болох ба өөрөөр хэлбэл тухайн тохиолдолд тохиромжтой аргыг сонгон авч сунгасан гарын зарчмаархи хамгийн сайн үнийг тогтооно гэсэн үг юм.

## ҮШ-ийн баримтжуулалт ба тайлагнах шаардлага

### ҮШ-ийн баримтжуулалт

- ҮШ-ийн зохицуулалтад хамаарах бүх ажил гүйлгээний баримтуудыг үйлдэн, байлгах шаардлагатай ба татварын алба шаардсан тохиолдолд 20 ажлын өдрийн дотор баримтуудыг гаргаж өгөх ёстой.

### ҮШ-ийн тайлагнах

- ҮШ-д хамааралтай татвар төлөгчид хагас болон бүтэн жилээр ажил гүйлгээгээ тайлагнах ёстой.
- Тайлагнах маягтууд (маягт ХХМ-01) Татварын Ерөнхий Газраас батлагдсан ба 2017 оны 2 дугаар улирлаас эхлэн тайлагнах үүрэгтэй болно.

\*2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн ТЕТ-ын даргын А/96 тоот тушаалаар баталсан

- ҮШ-ийн тайлан дараахи мэдээллийг агуулсан:

- ХХЭ-ийн мэдээлэл
- ХХЭ-ийн ажил гүйлгээний тухай мэдээлэл
- Ажил гүйлгээний орлого (ашиг), зардлын дүн, ашигт байдал
- Ажил гүйлгээнд ашигласан ҮШ-ийн аргууд
- Жишиг үнэд ашигласан харьцуулсан ААН-ийн жагсаалт
- Группын бүтцийн өнөөгийн өөрчлөлтийн тухай мэдээлэл
- Өмчлөлийн өөрчлөлтийн тухай мэдээлэл

Монголын татварын алба үнэ шилжилтийн асуудалд ихээхэн анхаарал хандуулж байна. ХХЭ-ийн ажил гүйлгээ бүхий бизнес эрхлэгчид ҮШ-ийн шаардлага өндөрсөж буй асуудлыг ойлгон, маш сайн мэдэж байх нь зохистой.

